



Эрсдэлийн үнэлгээ

Рэймонд Жирвэйс

2019 оны 2-р сар

Зорилго

Энэхүү сургалтын зорилго нь:

- ❖ Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд тулгарч болох **эрсдэлийг тооцоолж, үнэлэх**
- ❖ Эрсдэлийн болзошгүй нөлөөллийг тодорхойлж, арга хэмжээ авах талаарх **эрдсэлийн удирдлагын мөчлөг**
- ❖ **Эрсдэл үнэлгээний арга хэрэгслүүд**. Жишээ нь: эрсдэлийн матрикс

Эрсдэл болон Эрсдэлийн удирдлага гэж юу вэ?

Эрсдэл бол хүссэн үр дүнд хэрэхэд сөрөг эсвэл эерэг нөлөө үзүүлж болох боломжит үйл явдал юм.

Эрсдэлийн удирдлага нь эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, ойлгох, шийдвэр гаргах, мэдээлэл солилцох замаар үйл ажиллагааны хамгийн сайн чиглэлийг системтэйгээр тодорхойлоход чиглэгддэг.

Эрсдэлийн нэгдсэн удирдлага гэдэг нь байгууллагын эрсдэлийг тодорхойлж, удирдах, зохицуулах тасралтгүй үргэлжилсэн, идэвхтэй, системтэй үйл явц юм.

Төрийн байгууллага ба эрсдээлийн удирдлага

Канад улсад дараах зорилгоор Эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлсэн:

- Учирч болох ноцтой эрсдэлийг тодорхойлж, үнэлэн, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авснаар **Засгийн газрын удирдлагын хариуцлагатай** байдлыг сайжруулах
- Шийдвэр гаргахдаа эрсдэлийн талаар илүү мэдээлэлтэй байснаар **үр дүн сайжирна**
- Үүрэг хариуцлагыг **нэмэгдүүлэх**
- Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах замаар төрийн болон хувийн өмч, ашиг сонирхлыг хамгаалах **зохицуулалтыг сайжруулах**

Эх сурвалж: Канад улсын Сангийн яам. Эрсдэлийн нэгдсэн удирдлагын загвар, 2001

Олон улсын туршлага

Улс	Бодлого
АНУ	Бүх яаманд нийтээр баримтлах бодлого байхгүй боловч байгууллагад тусгайлан зориулсан бодлого, туршлага байдаг
Австрали	Төрийн удирдлагын үйл ажиллагаа, хариуцлагын акт, 2013 оноос хойш (Public Governance Performance and Accountability Act)
Англи	Сангийн яам (HM Treasury) 2004 оноос эрсдэл болон эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна
Сингапур	Эрсдэлийн удирдлагын талаар Засгийн газрын нэгдсэн бодлого гарсан.
Монгол	Төрийн байгууллагад баримтлах эрсдлийн талаар бодлого байдаг уу?
Эхний даалгавар:	Эрсдэлийн удирдлагатай холбоотой зүйлсийг нэгтгэн бичих

Эрсдэлийг удирдах үе шатууд



Эрсдэл

Эрсдэлийн удирдлагын мөчлөг



1-р шат: Эрсдэлийг тооцоолох, тодорхойлох

Ажлын үр дүнд нөлөөлж болохуйц эрсдэлийг тодорхойлохын тулд оролцогч талуудын дүн шинжилгээ болон тухайн ажилтай холбогдолтой мэдээллийг ашиглана.

Тодорхойлох арга:

- Зорилтод суурилан эрсдэл тодорхойлох арга
“Эрсдэлд өртөж болзошгүй үр дүн?”
- Нөхцөл байдалд суурилан эрсдэл тодорхойлох арга
“Ямар нөхцөл байдлаас эрсдэл үүсэх боломжтой вэ?”
- Ангилалд суурилан эрсдэл тодорхойлох арга
“Ямар төрлийн асуудал/бэрхшээл эрсдэл үүсгэх вэ?”

Даалгавар 2: Оролцогч талууд ба эрсдэл

Сонгосон жишээнээс хамаарч, тухайн үйл ажиллагаанд хамгийн их хамааралтай 4-5 оролцогч талуудыг жагсаан бичээрэй.

Дараа нь эрсдэлийн түвшинг 1(бага) - 4(өндөр) хүртэлх оноогоор үнэлнэ. Үр дүнд үзүүлэх нөлөөллийг **нэг өгүүлбэрт** багтаан товч тодорхойлон бичээрэй.

Оролцогч талууд	Эрсдлийн түвшин	Үр дүнд нөлөөлөх байдал

2-р шат: Эрсдэлийн үр дүнд үзүүлэх нөлөөг тодорхойлох

Хүрэх үр дүн болон үр дүнгийн **таамаглалын** талаар сайтар эргэцүүлж “Ямар үр дүнд эрсдэл тулгарах боломжтой вэ?” хэмээх асуултад хариулснаар

Шалтгаан үр дагаврын холбоогоор (хэрвээ... тэгвэл) эрсдэлийг тодорхойлж болно.

3-р шат: Авах арга хэмжээг тодорхойлох

Хүлээн зөвшөөрөх: Эрсдэлийг тооцоолж, үр дагавар, нөлөөллийг хүлээн зөвшөөрөх

Зайлсхийх: Таагүй үр дүн гарахаас зайлсхийх зорилгоор эрсдэлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах

Нөлөөллийг бууруулах: Учруулж болох хохирлын хэмжээг хязгаарласнаар нөлөөллийг бууруулах

Магадлалыг бууруулах: Урьдчилан сэргийлэх, урьдчилан таамаглах арга хэмжээ авснаар магадлалыг бууруулах

Судалгаа: Судалгаанд үндэслэсэн мэдээллийг цаг алдалгүй авах

Шилжүүлэх / хуваах: Нөлөөллийг өөр газар шилжүүлэх, хуваах байдлаар эрсдэлийг шийдвэрлэх.

3-р шат: Эрсдэл үнэлэх

Эрсдэл №	Эрсдэл	Холбогдох үр дүн	Авах арга хэмжээ: Ямар арга хэмжээ авах вэ? (эрсдэлийн боломжит нөлөөлөл,)?
1	Дараагийн сонгуулиар ажилтнууд солигдвол ҮДСУ-ын хэрэгжилт удааширна	АМГТГ-ын төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаандаа ҮДСУ-ийг хэрэгжүүлж буй мэргэжилтнүүдийн тоо өссөн байна	Үйл ажиллагаа: 1. Мэргэжилтнүүд солигдсоноос шалтгаалан гарах сөрөх нөлөөллийг багасгахын тулд бүх мэргэжилтнүүдийг ҮДСУ-ын чиглэлээр сургалтад хамруулах

4-р шат: Эрсдэлийн түвшинг тодорхойлох

Эрсдэл хоёр хэмжээстэй:

- **Магадлал:** Ирэх жилд эрсдэл тулгарах магадлал хэр их байгаа вэ?
- **Нөлөөлөл:** Хэрвээ эрсдэл тулгарвал хэрхэн нөлөөлөх вэ?

Нөлөөллийн түвшин, харилцан үйлчлэлийг тодорхойлохын тулд **эрсдэлийн матриксыг** ашиглана.

Канад улсын гадаад хэргийн яам – Нөлөөллийн хэмжээ


Нөлөөллийн хэмжээ

	Маш хязгаарлагдмал	Хязгаарлагдмал	Дунд зэрэг	Өндөр
	1	2	3	4
Эрсдэл тулгарвал хөтөлбөрт үзүүлэх НӨЛӨӨЛӨЛ	Хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, түүний үр дүнд маш бага нөлөө үзүүлнэ. Үр дагаврыг үйл ажиллагаа хэвийн явагдаж байх үеэр зохицуулах боломжтой.	Хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, түүний үр дүнд хязгаарлагдмал нөлөө үзүүлнэ. Үр дагаврыг бага зэргийн нэмэлт нөөц, үйл ажиллагаагаар зохицуулах боломжтой.	Хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, түүний үр дүнд дунд зэргийн нөлөө үзүүлнэ. Үр дагаврыг дунд зэргийн нэмэлт нөөц, үйл ажиллагаагаар зохицуулах боломжтой.	Хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт, түүний үр дүнд их нөлөө үзүүлнэ. Удирдлагын зүгээс төлөвлөгөө болон нөөцийн хуваарилалтад том хэмжээний өөрчлөлт оруулах шаардлагатай.

Эрсдэлийн матрикс : Байгаль орчны жишээ

			Магадлал					
			1	2	3	4	5	6
			Бараг үгүй	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Үр дагавар	A	Онц их аюултай						
	B	Их аюултай					Маш их	
	C	Аюултай				Их		
	D	Дунд зэрэг			Дунд			
	E	Бага зэрэг		Бага				
	F	Маш бага						

Эрсдэлийн матриксийн хялбар загвар: Дэлхийн хүнсний хөтөлбөр



Даалгавар 4: Эрсдэлийн матрикс ашиглах

Жишээн дээр ажиллан тодорхойлсон эрсдэлүүдээ дэлхийн хүнсний хөтөлбөрийн хялбар матриксыг ашиглан ангилна уу.

5-р шат: Хянах, сайжруулах, тайлагнах

Сайн **хяналт-шинжилгээний систем** бий болгон, **ил тод тайлагнаж**, мөн

эрсдэлийн үнэлгээг тухайн нөхцөл байдалд **тохируулан хийснээр**



Үр дүнд хүрэхэд саад болж болзошгүй нөлөөллийг багасгаж, урьдчилан сэргийлнэ.



Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower
Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160
Mongolia

Phone: 7610-5000